



МОНГОЛ УЛСЫН  
УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЙДЫН ТУШААЛ

2016 оны 09 сарын 12 өдөр

Дугаар 22

Улаанбаатар хот

Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтийн асуудлаар санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий Мэргэжлийн зөвлөлийн ажиллах журам, бүрэлдэхүүн батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1, Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, мөн зүйлийн 6.1.3, 7 дугаар зүйл, Засгийн газрын 2013 оны 139 дүгээр тогтоолоор баталсан Мэргэжлийн зөвлөлийн дүрмийн 1.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтийн асуудлаар санал, дүгнэлт, зөвлөмж гаргах үүрэг бүхий Мэргэжлийн зөвлөлийн ажиллах журмыг нэгдүгээр хавсралтаар, Мэргэжлийн зөвлөлийн бүрэлдэхүүнийг хоёрдугаар хавсралтаар, үйлдвэрлэлийн зориулалтаар тэсэлгээний ажил хийх, тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл импортлох, үйлдвэрлэх, худалдах, тэсэлгээний ажил, үйлчилгээ хийх аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл хүсэхэд бүрдүүлэх материалын жагсаалтыг гуравдугаар хавсралтаар, тэсрэх бодисын үйлдвэрийн техник-эдийн засгийн үндэслэлд тавигдах шаардлага ба хүлээн авах зааврыг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.
2. Батлагдсан журам, зааврыг үйл ажиллагаандaa мөрдөж ажиллахыг Мэргэжлийн зөвлөлийн дарга, Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын даргад үүрэг болгосугай.
3. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Уул уурхайн сайдын “Мэргэжлийн зөвлөлийн бүрэлдэхүүн, Мэргэжлийн зөвлөлийн ажиллах журам батлах тухай” 2013 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн 85 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.



Ц.ДАШДОРЖ

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын  
2016 оны 9 дугаар сарын 22-ны өдрийн  
22 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

ТЭСЭРЧ ДЭЛБЭРЭХ БОДИС, ТЭСЭЛГЭЭНИЙ ХЭРЭГСЛИЙН ЭРГЭЛТИЙН  
АСУУДЛААР САНАЛ, ДҮГНЭЛТ ГАРГАХ ҮҮРЭГ БҮХИЙ МЭРГЭЖЛИЙН  
ЗӨВЛӨЛИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ

XA0580 9129294

Нэг. Ерөнхий зүйл

1.1. Уг журмын зорилго нь Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтийн асуудлаар санал, дүгнэлт гаргах Мэргэжлийн зөвлөл /цаашид "Зөвлөл" гэх-/ийн үйл ажиллагааг зохицуулахад оршино.

1.2. Журмын үйлчлэх хүрээ нь тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтийн асуудалтай холбоотой хуулийн этгээд, түүнд хяналт тавих эрх бүхий байгууллагуудын хуулиар хүлээсэн үүргийг хэрэгжүүлэхэд хамарагдана.

1.3. Журамд өөрчлөлт оруулах асуудлыг Зөвлөл гаргаж Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдад танилцуулж шийдвэрлүүлнэ.

Хоёр. Зөвлөлийн ажлын зохион байгуулалт

2.1. Зөвлөлийн үндсэн үйл ажиллагаа нь хуулийн этгээдийн бүрдүүлсэн бичиг баримтыг хүлээн авах, гишүүдэд танилцуулах, холбогдох байгууллагуудын саналыг авах, Зөвлөлийн хурлыг зохион байгуулах, хурлын албан ёсны санал, дүгнэлт, зөвлөмжийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдад танилцуулж холбогдох шийдвэр гаргуулахад чиглэгдэнэ.

2.2. Зөвлөлийн хурлаар дараах асуудлыг хэлэлцэж, шийдвэрлэнэ. Үүнд:

2.2.1. тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтийн асуудлаар санал, дүгнэлт гаргана.

- Дотоодод үйлдвэрлэж байгаа тэсрэх бодисын хэмжээтэй уялдуулан тухайн төрлийн тэсрэх бодисын импортын талаар санал боловсруулах;

2.2.2. үйлдвэрлэлийн зориулалтаар тэсэлгээний ажил хийх, тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл импортлох, экспортлох, худалдах, үйлдвэрлэх, тэсэлгээний ажил, үйлчилгээ хийх аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл олгох, сунгах талаар санал, дүгнэлт гаргана.

- Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл хүссэн хуулийн этгээдийн тухайн тусгай зөвшөөрлийн хүсэлттэй холбоотой бүрдүүлэх материалын жагсаалтыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын тушаалаар батлуулсан байна.

- Тусгай зөвшөөрлийн хүсэлттэй холбоотой бүрдүүлэх материалд хуулийн дагуу санал өгөх байгууллагууд дотооддоо мөрдөх журам боловсруулж батлуулсан байна.

2.2.3. тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хууль, аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, дүрэм, заавар зөрчсөн хуулийн этгээдийн аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох талаар санал гаргана.

- Хуулийн этгээдийн гаргасан зөрчлийг хууль, хяналтын байгууллагаар баталгаажуулсан байна.

2.2.4. тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн үйлдвэр, агуулахын зураг төсөл, техник-эдийн засгийн үндэслэлийг хэлэлцэж дүгнэлт гаргана.

- Тэсрэх бодисын үйлдвэрийн техник-эдийн засгийн үндэслэлд тавигдах үндсэн шаардлага ба хулээн авах зааврыг дагаж мөрднө.
- Тэсрэх материалын агуулахын зураг төслийг Монгол Улсын Зөвлөх инженерээр шинжээчийн дүгнэлт гаргуулан Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын улсын байцаагчаар хянуулсан байна.

2.2.5. шинэ төрлийн тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлт, шинэ технологи нэвтрүүлэх, үндэсний стандартыг бий болгох талаар санал, зөвлөмж гаргана.

- Шинэ нэр төрлийн тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн хэрэглээ, технологийн талаар судалгаа хийсэн байна.
- Шинэ төрлийн тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэлд үндэсний стандарт олгох талаар санал, зөвлөмж гаргана.

2.2.6. тэсрэх бодисын үйлдвэр, тэсрэх материалын агуулахын аюулгүйн бүс, түүний дэглэмийг тогтооно.

2.2.7 зөвлөрийн тэсрэх бодисын үйлдвэр, тоног төхөөрөмжид санал, дүгнэлт гаргана.

2.3. Зөвлөлийн хурлыг сар бүрийн гурав дахь долоо хоногийн дөрөв дэх өдөр хийх ба ээлжит бус хурлыг Зөвлөлийн дарга зарлан хуралдуулж болно.

2.4. Зөвлөлийн хурлыг Зөвлөлийн дарга, түүний эзгүйд Зөвлөлийн орлогч даргална.

2.5. Зөвлөлийн хурлаар энэхүү журмын 2.2.2-т заасан асуудал хэлэлцүүлэх хуулийн этгээдийн бүрдүүлэх материал хуульд заасан шаардлагыг хангагүй тохиолдолд хэлэлцэхгүй буцаана.

2.6. Асуудал хэлэлцүүлэх хуулийн этгээд нь батлагдсан жагсаалтын дагуу холбогдох материалыг бүрдүүлж Уул уурхай, хүнд үйлдвэрийн яаманд хүргүүлнэ. Бүрдүүлсэн материалыг зөвлөлийн гишүүдэд цахим байдлаар тараагдахаар бэлтгэсэн байна.

2.7. Зөвлөлийн нарийн бичгийн дарга нь материалын бурдлийг шалгаж хүлээн авна. Хурлын материалыг Зөвлөлийн нарийн бичгийн дарга хурал болохоос 5 хоногийн өмнө Зөвлөлийн гишүүдэд тараана.

2.8. Хуулийн этгээдээс ирүүлсэн материалын бурдлийг судлаж үзээд шаардлагатай тохиолдолд Зөвлөлийн дарга тухайн объект дээр мэргэжлийн шинжээчийг томилон ажиллуулж болно.

2.9. Зөвлөлийн хурлыг гишүүдийн 2/3-аас доошгүй хувь ирсэн тохиолдолд хуралдуулна.

2.10. Асуудал хэлэлцүүлж байгаа хуулийн этгээд нь Зөвлөлийн хуралд хэлэлцүүлэх асуудлаар танилцуулга хийнэ.

2.11. Зөвлөлийн хурлаар хэлэлцсэн асуудлыг гишүүдийн дийлэнх олонхийн саналаар шийдвэрлэж, санал, дүгнэлт гаргана. Санал, дүгнэлтэд зөвлөлийн дарга болон нарийн бичгийн дарга гарын үсэг зурж баталгаажуулна.

2.12. Зөвлөлийн хурлын тэмдэглэлийг нарийн бичгийн дарга хөтөлж, Зөвлөлийн дарга гарын үсэг зурна.

Гурав. Зөвлөлийн эрх, үүрэг

3.1. Тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтийн мэдээллийн нэгдсэн санг баяжуулах, тогтмол ажиллуулах,

3.2. Хууль тогтоомж сахиулах, сурталчлах, хэрэгжүүлэх байдалд дэмжлэг үзүүлэх,

3.3. Зөвлөл нь холбогдох төрийн бус байгууллагуудтай хамтран тэсрэх бодисын үйлдвэр, агуулах барих аж ахуйн нэгжүүдэд богино хугацааны сургалт хийх.

Дөрөв. Зөвлөлийн ажлыг тайлагнах

4.1. Зөвлөл нь хурлаас гарсан шийдвэрийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдад тухай бүр танилцуулна.

4.2. Төрийн байгууллагаас томилогдсон төлөөлөлүүд нь Зөвлөлийн хурлаар хэлэлцэж шийдвэрлэсэн санал, дүгнэлтээ харьяа байгууллагын удирдлагад тухай бүр тайлagnана.

4.3. Тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн хэрэглээний (ашиглалтын) талаарх нэгдсэн мэдээллийг Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Ажлын албандаа жил тутам хүргүүлнэ.

-----oOo-----

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын  
2016 оны 09 дугаар сарын 12 –ны өдрийн  
22 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

МЭРГЭЖЛИЙН ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

УХА0580 9129294

Мэргэжлийн зөвлөлийн дарга:

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга

Мэргэжлийн зөвлөлийн орлогч дарга:

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Уул уурхайн бодлогын газрын дарга

Гишүүд:

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Уул уурхайн бодлогын газрын төлөөлөл

Ашигт малтмалын газрын Уул уурхайн хэлтсийн төлөөлөл

Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын төлөөлөл

Зэвсэгт хүчний жанжин штабын төлөөлөл

Тагнуулын ерөнхий газрын төлөөлөл

Цагдаагийн ерөнхий газрын төлөөлөл

Онцгой байдлын ерөнхий газрын төлөөлөл

ШУТИС-ын Геологи, уул уурхайн сургуулийн төлөөлөл

Тэсэлгээний инженерийн холбооны төлөөлөл

Уул уурхайн зураг, төсөл зохиогчдын холбооны төлөөлөл


Тэсэлгээний ажил, үйлчилгээ эрхлэгчдийн холбооны төлөөлөл

Уул уурхайн хүрээлэнгийн төлөөлөл

Мэргэжлийн зөвлөлийн нарийн бичгийн дарга:

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын мэргэжилтэн

-----оо-----



Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын  
2016 оны 9 дугаар сарын 22 –ны өдрийн  
22 дугаар тушаалын гуравдугаар хавсралт

Нэг. "Үйлдвэрлэлийн зориулалтаар тэсэлгээний ажил хийх" тусгай зөвшөөрөл авах болон хугацаа сунгах хүсэлт гаргахад бүрдүүлэх материалын жагсаалт.

1. Уул уурхай, хүнд үйлдэрийн яаманд хандсан хүсэлт /албан тоот/
2. Аж ахуйн нэгжийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар
3. Ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн хуулбар /сүүлийн жилийн төлбөр хийсэн/
4. Холбогдох газруудын санал
  - Тагнуулын ерөнхий газар
  - Цагдаагийн ерөнхий газар
5. Тэсэлгээчний үнэмлэхний хуулбар
6. Агуулахын тодорхойлолт, фото зураг
7. Тэсэлгээ хийх талбай, уурхайн дэвсгэр зураг /агуулах байршуулсан/
8. Хайгуулын болон уулын ажлын төлөвлөгөөний баталгаажуулсан нүүр хуудасны хуулбар
9. Өрөмдлөг, тэсэлгээний ажлын паспорт
10. Тусгай зөвшөөрлийн тэмдэгтийн хураамж төлсөн баримт
11. Тэсэлгээний удирдагчийн ажил байдлын тодорхойлолт, дипломын хуулбар
12. Өмнөх жилүүдэд авсан тэсэлгээний ажил хийх эрхийн хуулбар
13. Тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн зарцуулалтын тооцоо
14. Тэсэлгээний ажил явуулах зориулалтын тоног төхөөрөмж, тээврийн хэрэгслийн тодорхойлолт
15. Гэрээт харуул хамгаалалтын байгууллагатай хийсэн гэрээ, танилцуулга
16. Гамшигийн эмзэг байдал, эрсдлийн үнэлгээ,
17. Гамшиг, аюул ослын үед хэрэгжүүлэх төлөвлөгөө, галын ажлын байрны дүгнэлт
18. Агуулахын газар эзэмших гэрчилгээ, Засаг даргын захирамж
19. Аяnga эсэргүүцлийн хэмжилт хийлгүүлсэн протокол

Хоёр. "Үйлдвэрлэлийн зориулалттай тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл импортлох, экспортлох, үйлдвэрлэх, худалдах" тусгай зөвшөөрөл авах болон хугацаа сунгах хүсэлт гаргахад бүрдүүлэх материалын жагсаалт.

1. Уул уурхай, хүнд үйлдэрийн яаманд хандсан хүсэлт /албан тоот/
2. Аж ахуйн нэгжийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар
3. Холбогдох газруудын санал
  - Тагнуулын ерөнхий газар
  - Цагдаагийн ерөнхий газар
  - Зэвсэгт хүчиний жанжин штаб
4. Боловсон хүчиний талаар мэдээлэл, тэсэлгээчний үнэмлэхний хуулбар
5. Агуулахын тодорхойлолт, фото зураг
6. Агуулахын барилгад хийсэн мэргэжлийн байгууллагын дүгнэлт
7. Тусгай зөвшөөрлийн тэмдэгтийн хураамж төлсөн баримт
8. Зориулалтын тоног төхөөрөмж, тээврийн хэрэгслийн тодорхойлолт
9. Байгаль орчинд нелөөлөх байдлын наричилсан үнэлгээ

10. Гамшигийн эмзэг байдал, эрсдлийн үнэлгээ,
11. Гамшиг, аюул ослын үед хэрэгжүүлэх төлөвлөгөө, галын ажлын байрны дүгнэлт
12. Үйлдвэрлэлийн аюулгүй ажиллагааны техникийн шаардлага хангасан зориулалтын барилга байгууламж, тоног төхөөрөмж, лаборатори, туршилтын талбайн дүгнэлт
13. Тэсрэх материалын чанарын үзүүлэлтийг тогтоосон үндэсний болон олон улсын стандартын шаардлага хангасан сертификат
14. Үйлдвэрлэл эрхлэх эрх бүхий хуулийн этгээдийн хувьцааны 51-ээс доошгүй хувийг Монгол Улсын иргэн, хуулийн этгээд эзэмшиж байгаа талаарх бичиг баримт
15. Экспортлох бүтээгдэхүүний стандарт, техникийн шаардлага хангасан байдлын талаарх мэргэжлийн итгэмжлэгдсэн байгууллагын тодорхойлолт, экспортлох тоо хэмжээ, худалдан авагчтай урьдчилан байгуулсан гэрээ, иргэний зориулалтын батламж, тээвэрлэлтийн нөхцлийг тусгасан баримт бичиг

Гурав. "Үйлдвэрлэлийн зориулалтаар тэсэлгээний ажил, үйлчилгээ хийх" тусгай зөвшөөрөл авах болон хугацаа сунгах хүсэлт гаргахад бүрдүүлэх материалын жагсаалт.

1. Уул уурхай, хүнд үйлдэрийн яаманд хандсан хүсэлт /албан тоот/
2. Аж ахуйн нэгжийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар
3. Холбогдох газруудын санал
  - Тагнуулын ерөнхий газар
  - Цагдаагийн ерөнхий газар
4. Тэсэлгээчний үнэмлэхний хуулбар
5. Өрөмдлөг, тэсэлгээний ажлын паспорт /ил ба далд аргаар олборлолт явуулах үеийн/
6. Тусгай зөвшөөрлийн тэмдэгтийн хураамж төлсөн баримт
7. Тэсэлгээний удирдагчийн ажил байдлын тодорхойлолт, дипломын хуулбар
8. Тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн зарцуулалтын тооцоо
9. Тэсэлгээний ажил явуулах зориулалтын тоног төхөөрөмж, тээврийн хэрэгслийн тодорхойлолт
10. Гэрээт харуул хамгаалалтын байгууллагатай хийсэн гэрээ, танилцуулга
11. Гамшигийн эмзэг байдал, эрсдлийн үнэлгээ,
12. Гамшиг, аюул ослын үед хэрэгжүүлэх төлөвлөгөө, галын ажлын байрны дүгнэлт
13. Агуулахын газар эзэмших гэрчилгээ, Засаг даргын захирамж
14. Аянга эсэргүүцлийн хэмжилт хийлгүүлсэн протокол

**Тайлбар:** Данс

Улаанбаатар банк, Чингэлтэй дүүргийн Татварын хэлтэс

Данс – 2611016627

Төлбөрийн хэмжээ – 3'250'000=00 төгрөг

Тусгай зөвшөөрлийн тэмдэгтийн хураамж

Дөрөв. "Үйлдвэрлэлийн зориулалтаар тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл импортлох зөвшөөрөл (лицензи)" авах хүсэлт гаргахад бүрдүүлэх материалын жагсаалт.

1. Уул уурхай, хүнд үйлдэрийн яаманд хандсан хүсэлт /албан тоот/
2. Экспорт, импортын зөвшөөрөл /лицензи/ олгох тухай өргөдөл
3. Аж ахуйн нэгжийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар
  - Холбогдох газруудын санал
  - Тагнуулын ерөнхий газар
4. Цагдаагийн ерөнхий газар

5. Гадаад гэрээний хуулбар
6. Гадаад гэрээний орчуулга
7. Зөвшөөрөл /лицензи-/ийн тэмдэгтийн хураамж төлсөн баримт
8. Тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл импортлох аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн хуулбар

**Тайлбар: Данс**

Улаанбаатар банк, Чингэлтэй дүүргийн Татварын хэлтэс

Данс – 2611016627

Төлбөрийн хэмжээ – 50'000=00 төгрөг

Зөвшөөрөл /лицензи-/ийн тэмдэгтийн хураамж

-----oOo-----

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын  
2016 оны 9 дугаар сарын 22-ны өдрийн  
22 дугаар тушаалын дөрөвдүгээр хавсралт

ТЭСРЭХ БОДИСЫН ҮЙЛДВЭРИЙН ТЕХНИК-ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДЭСЛЭЛД ТАВИГДАХ  
ҮНДСЭН ШААРДЛАГА БА ХҮЛЭЭН АВАХ ЗААВАР

Нэг. Ерөнхий зүйл

1. Энэхүү зааврын зорилго нь Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх хэсэгт заасныг үндэслэн холбогдох дүрэм, журам, стандартын шаардлагад нийцүүлэн тэсрэх бодисын үйлдвэрийн төслийн техник-эдийн засгийн үндэслэлд тавигдах үндсэн шаардлагууд ба техник-эдийн засгийн үндэслэлийг хэлэлцэх, хүлээн авахтай холбоотой бүхий л үйл ажиллагааг зохицуулахад оршино.
2. Энэхүү заавраар тэсрэх бодисын үйлдвэрийн төслийн техник-эдийн засгийн үндэслэлийг хэлэлцэх, хүлээн авах, төсөл хэрэгжүүлэгч болон төсөл боловсруулагчид тавигдах шаардлага, төсөл хэлэлцүүлэгч Мэргэжлийн зөвлөлийн хоорондын харилцааг зохицуулна.

Хоёр. Зааврын нэр томъёоны тодорхойлолт

- 2.1. Энэхүү журамд хэрэглэсэн дараах нэр томъёоны тодорхойлолтыг дор дурдсан утгаар ойлгоно. Үүнд:

2.1.1. “*Тэсрэх бодисын үйлдвэрийн төслийн техник-эдийн засгийн үндэслэл*” гэж Монгол Улсын Засгийн газраас баталсан “Монгол Улсын нутаг дэвсгэрт эргэлтийг зөвшөөрөх, олон улсад бүртгэлтэй тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн жагсаалт”-ын дагуу үйлдвэрлэх тэсрэх бодисын үйлдвэрийн төслийг хэрэгжүүлэхэд чиглэсэн үйлдвэрийн техник, технологийн сонголт, тооцоо, инженерийн шийдэл, байгаль орчин, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, хүний нөөц, удирдлага, зохион байгуулалт, дэд бүтэц, хангамж, нийгэм, ахуйн үйлчилгээ, эдийн засгийн үр ашгийн тооцоо, тайлбар хэсгээс бүрдэх техникийн баримт бичгийг;

2.1.2. “*Төсөл хэрэгжүүлэгч*” гэж Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.5 дах хэсэгт заасан шаардлагыг хангаж байгаа энэ талын үйлдвэрлэл эрхлэх санхүү, хүний нөөцийн боломжтой хуулийн этгээдийг;

2.1.3. “*Төсөл боловсруулагч*” гэж Геологи, уул уурхайн эрдэм шинжилгээ, судалгаа, зураг төслийн эрх бүхий байгууллага, аж ахуйн нэгж байх ба энэ чиглэлийн эрх бүхий Монгол Улсын зөвлөх инженерээр зөвлүүлсэн хуулийн этгээдийг;

2.1.4. “*Шинжээч*” гэж Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн чиглэлээр мэргэшсэн болон зөвлөх инженерийн зэрэгтэй инженерийг хэлнэ.

Гурав. Тэсрэх бодисын үйлдвэрийн төслийн техник-эдийн засгийн үндэслэл  
боловсруулахад тавигдах шаардлага

- 3.1. Тэсрэх бодисын үйлдвэрийн техник-эдийн засгийн үндэслэлийг боловсруулахад дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:
  1. Нүүр хуудас - Техник-эдийн засгийн үндэслэлийн гарчиг, төслийн хүчин чадал
  2. Огноо, гарын үсэгний хуудас – Огноо бичиж, гарын үсэг зурна. Үүнд:
    - а) Мэргэжлийн зөвлөлийн даргын гарын үсэг, тэмдэг дарна.
    - б) Төсөл хэрэгжүүлэгчийн удирдлагын гарын үсэг, тамга дарна.
    - в) Мэргэжлийн зөвлөлийн нарийн бичгийн даргын гарын үсэг
    - г) Төсөл боловсруулагчийн удирдлагын гарын үсэг, тамга дарна.

- e) Төсөл боловсруулагчийн Монгол Улсын зөвлөх инженерийн гарын үсэг, тамга дарна.
  - f) Төсөл боловсруулагчийн инженер, техникийн ажилтны гарын үсэг.
  - g) Төсөлд шинжээч хийсэн шинжээчийн гарын үсэг, Монгол Улсын мэргэшсэн болон Зөвлөх инженер бол тамга дарна.
3. Гарчиг— Техник-эдийн засгийн үндэслэлийн агуулгыг жагсаана.
4. Хүснэгт, зургийн жагсаалт- Техник, эдийн засгийн үндэслэлд оруулсан бүх хүснэгт, зургуудын жагсаалт.
5. Төвч дүгнэлт- Техник-эдийн засгийн үндэслэлийн гол гол мэдээллийг дүгнэнэ.
6. Танилцуулга—Дараах зүйлсийг оруулсан байна. Үүнд:
- a) Техник-эдийн засгийн үндэслэлийн удирдамж, зорилго
  - b) Төсөл боловсруулагчийн мэдээлэл.
  - c) Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл.
  - d) Техник-эдийн засгийн үндэслэлд дурдагсан болон боловсруулах явцад ашигласан мэдээ, тоо баримтын эх сурвалжууд.
  - e) Техник-эдийн засгийн үндэслэлийн товчлол.
  - f) Судалгааны түвшин-дэлгэрэнгүй инженерийн шийдлийн тооцоонд үндэслэнэ.
  - g) Үйлдвэрийн нарийвчилан тооцсон хүчин чадал.
  - h) Байгаль орчныг хамгаалах шаардлагууд болон хуулийн дагуу шаардлагатай зөвшөөрлүүд
  - i) Үйлдвэр байгуулах болон үйлдвэрийн ажиллах хугацаа
  - j) Хөрөнгө оруулалтын хэмжээ-нарийвчилсан тооцоо.
  - k) Эдийн засгийн үндсэн үзүүлэлт-нарийвчилсан тооцоо.
  - l) Өнөөгийн үнэ цэнэ, дотоод өгөөжийн түвшин /NPV, IRR, ROI/- нарийвчилсан тооцоо.
7. Үйлдвэрлэл
- a) Тоног төхөөрөмжийн сонголт бүтээлийн тооцоо-нарийвчилсан тооцоо судалгаа.
  - b) Үйлдвэрийн ерөнхий бүтцийн дэвсгэр зураг
  - c) Хөрөнгө оруулалтын тооцоо
  - d) Процесс бүрийн технологийн схем
  - e) Түүхий эдийн судалгаа
  - f) Ус таталт, цахилгаан хангамж, гадаад, дотоод цахилгаан хангамж, схем, кабель шугам, газардуулга, реле хамгаалалт, гэрэлтүүлэг зэргийн тооцоо
  - g) Хаягдлын аж ахуйн тооцоо, зураг, схем
  - h) Химийн бодисын хэрэглээ
  - i) Саармагжуулах, хоргуйжүүлэх судалгаа тооцоо
  - j) Тоног төхөөрөмжийн холбоос зураг
  - k) Талбайн зураг
8. Дэд бүтэц
- a) Дэд бүтцийн байгууламжийн жагсаалт
  - b) Эрчим хүч, усны хангамжийн үзүүлэлтүүд-эрчим хүчиний хэрэглээ, хангамжийн схем.
  - c) Үйлдвэрлэлийн нэгжүүдийн нэгдсэн зураг
  - d) Дэд бүтцийн хөрөнгө оруулалт, удирдлагын зардлын хэмжээ, ажиллах хүчиний тооцоо, жагсаалт
9. Хөдөлмөрийн эрүүл ахуй, нийгмийн асуудал, аюулгүй ажиллагаа, эрсдэлийн менежмент
- a) Хөдөлмөрийн эрүүл ахуй, нийгмийн асуудал, ажлын байрны эрүүл ахуй, мэргэжлээс шалтгаалах өвчинеэс урьдчилан сэргийлэх арга хэмжээг төлөвлөн зардлыг тусгах
  - b) Аюулгүй ажиллагааг баримтлах - аюулгүй ажиллагааны дүрмүүд, стандартууд, сургалт зааварчилгаатай холбоотой зардлыг төлөвлөн тусгах.
  - c) Аюул ослын үед хэрэгжүүлэх төлөвлөгөө.
10. Байгаль орчин
- a) Байгаль орчныг хамгаалах удирдлагын систем
  - b) Байгаль орчинд нөлөөлөх сөрөг нөлөөллийг багасгах төлөвлөгөө
  - c) Үйлдвэрийн хаягдлын аж ахуйн удирдлага
  - d) Уусмал болон хортой бодисын хадгалалт, саармагжуулалт
  - e) Хөрсөнд хортой бодис нэвчихээс сэргийлэх ажил
  - f) Гамшигийн эмзэг байдал эрсдлийн үнэлгээ.
  - g) Эрсдлээс хамгаалах төлөвлөгөө
11. Төсөл хэрэгжүүлэх төлөвлөгөө - төсөл хэрэгжүүлэх хугацааны график

12. Эдийн засаг, санхүүгийн үнэлгээ
- a) Эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд
  - b) Борлуулалтын үнэлгээ, орлого
  - c) Үйл ажиллагааны зардал
  - d) Эдийн засгийн үр ашгийн тооцоо
  - e) Улс орон нутгийн төсөвт оруулах орлого
  - f) Мөнгөн гүйлгээний төлөв
  - g) Мэдрэмжийн шинжилгээ
  - h) Өнөөгийн үнэ цэнэ, дотоод өгөөжийн түвшин /NPV, IRR, ROI/-ийн нарийвчилсан тооцоо.
  - i) Хөрөнгө оруулалтаа нөхөх хугацаа- нарийвчилсан тооцоо.

3.2. Гадаадын байгууллагын боловсруулсан техник, эдийн засгийн үндэслэлийг төсөл боловсруулагч Монгол Улсад мөрдөгдөж байгаа хууль, дүрэм, зааварт нийцүүлж засварлана.

3.3. Холбогдох зургуудыг компьютерийн мэргэжлийн программын тусламжтай үйлдсэн байна.

**Дөрөв. Техник-эдийн засгийн үндэслэлийг хадгалах,  
ашиглах ба шинэчлэн боловсруулах**

4.1. Техник-эдийн засгийн үндэслэлийг хэвлэмэл болон цахим хэлбэрээр тус бүр хоёр хувь үйлдсэн байх бөгөөд төсөл хэрэгжүүлэгч, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яаманд тус тус нэг хувийг хадгална.

4.2. Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам нь хүлээн авсан техник-эдийн засгийн үндэслэлийн хэвлэмэл болон цахим хувилбарыг үйлдвэрийн ашиглалтын үйл ажиллагаанд хяналт тавих зорилгоор ашиглана.

4.3. Тэсрэх бодисын үйлдвэрийн төсөлд хүчин чадал, техник, технологийн өөрчлөлт орсон, уг техник-эдийн засгийн үндэслэлийг боловсруулсанаас хойш үйлдвэрлэл явуулаагүй 3-аас дээш жилийн хугацаа өнгөрсөн, тусгай зөвшөөрөл өөрчлөгдсөн тохиолдолд болон тухайн техник-эдийн засгийн үндэслэлийг хүлээн авсанаас хойш 5 жил тутамд төсөл хэрэгжүүлэгч байгууллага техник-эдийн засгийн үндэслэлийг тодотгох, шинэчлэх буюу шинээр боловсруулах үүргийг хүлээнэ.

**Тав. Техник-эдийн засгийн үндэслэлийг хүлээж авах**

5.1. Тэсрэх бодисын үйлдвэрийн техник-эдийн засгийн үндэслэлийг захиалж хийлгэсэн төсөл хэрэгжүүлэгч нь түүний хэвлэмэл болон цахим хэлбэрээр хийсэн тус бүр нэг хувийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Бодлогыг хэрэгжүүлэх газарт ирүүлэх бөгөөд тус газар нь санал, дүгнэлтээ гарган Мэргэжлийн зөвлөлд хүргүүлнэ.

5.2. Техник-эдийн засгийн үндэслэлд шинжээчийг томилон шинжээчийн дүгнэлт гаргуулна.

5.3. Шинжээчийн ажлын хөлсийг харилцан тохиролцох замаар шийдвэрлэх ба төсөл захиалагч хариуцна.

5.4. Шинжээчид ба төсөл захиалагч талууд тухайн төсөлд санал шүүмж өгөхөд аль нэг нь татгалзсан бол шинжээчтэй холбоотой асуудлыг Мэргэжлийн зөвлөлд дахин санал гаргах боломжтой.

5.5. Мэргэжлийн зөвлөлийн хуралд техник-эдийн засгийн үндэслэлийг хэлэлцүүлэхээс өмнө төсөл боловсруулагч шинжээчийн дүгнэлтэд хариу өгч шинжээч өгсөн хариуг хүлээн зөвшөөрч байгаа эсэхийг баталгаажуулсан байна.

5.6. Техник-эдийн засгийн үндэслэлийг Мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэхэд төсөл захиалагч байгууллага танилцуулах бөгөөд асуулт хариултад төсөл боловсруулагч албан ёсоор хариулт өгнө.

5.7. Шинжээч нь Мэргэжлийн зөвлөлийн хуралд оролцох боломжгүй тохиолдолд түүнээс Мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх саналыг албан ёсоор авсан байна.

5.8. Мэргэжлийн зөвлөл техник-эдийн засгийн үндэслэлийг хүлээн аваад тус зөвлөлийн хурлаар хэлэлцэн түүнийг ашиглахыг зөвшөөрөх эсэх шийдвэрээ гарган дүгнэлт үйлдэж Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдад уламжилна.

-----oOo-----